



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 06 өдөр

Дугаар A/146

Зуунмод

г) Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
ажиллах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, 4 дүгээр зүйлийн 4.3-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд коронавируст халдвартын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан Зуунмод суманд хөл хорионы дэглэмийг 2021 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 20:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 20:00 цаг хүртэл тогтоосугай.

2. Хөл хорионы дэглэм тогтоосонтой холбогдуулан аймгийн Онцгой комисс, Зуунмод сумын Онцгой комисс, аймгийн Шуурхай штаб, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, онц чухал стратегийн зориулалттай байгууллага харилцаа холбоо, усан хангамж, дулаан, цахилгаан түгээх компаниудаас бусад бүх байгууллага аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүрэн зогсоож, зорчих хөдөлгөөнийг хязгаарласугай.

3. Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимд шилжүүлж, хөл хорионы үеийн бэлтгэл бэлэн байдлыг ханггуулж ажиллахыг хэлтэс, агентлаг, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Хөл хорионы дэглэмийн үед ариутгал халдвартгүйтгэлийг зохион байгуулж, хүнсний худалдаа, эмийн сангийн үйл ажиллагааг тусгай нөхцөл, шаардлага зөвлөмжийн дагуу үе шаттай нээж ажиллуулахыг Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл)-д даалгасугай.

5. Зуунмод сумын доторх иргэн, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг бүрэн хязгаарлах, бусад аймаг орон нутагт дамжин өнгөрч байгаа иргэдийг нотлох баримтыг үндэслэн хөдөлгөөн үйлдүүлж, хяналт тавьж зорчуулахыг Цагдаагийн газар (Б.Ганзориг), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт даалгасугай.

6. Халдварт илэрсэн иргэдийн ойрын болон дам хавьтлыг тогтоож тусгаарлах арга хэмжээг авах, ажиглан тусгаарлах байрыг сонгож, халдварт хамгааллын дэглэмийг сахиулахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т нарт үүрэг болгосугай.

7. Зуунмод суманд коронавируст халдварт илэрсэнтэй холбогдуулан бусад сумдаас Зуунмод суманд ирэх хөдөлгөөнийг Бүрэн хязгаарлаж, халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Зуунмод суманд Хөл хорионы хугацаанд “Нэг өрх-Нэг шинжилгээ”-г зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаж, өндөр түвшинд хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг) нарт даалгасугай.

9. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын орлогч, дарга бөгөөд Онцгой байдлын газрын дарга (Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР

